



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цэцэрлэг сумын ИТХ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2022/134/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Цэцэрлэг хот
2022 он

Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын тэргүүлэх аудитор: Т.Байгалмаа
Утас: 70333141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Нэргүйбаатар
Утас: 70332680 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn

Аудитор: П.Энхжаргал
Утас: 99743112
Цахим хаяг: enkhjargalp@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	3
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	4
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	6
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	7
3. Аудитын тайлан.....	7
3.1 Ерөнхий зүйл.....	7
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	8
3.4 Материаллаг байдал	8
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	9
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	10
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	10
3.8 Аудитын гол асуудал	10
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	11
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	11
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	11
3.12 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	12
4. Аудитын илрүүлэлт	12
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	12

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын тамгын газар

1.Аудитын санал дүгнэлт**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс: 976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

2022.02.24 № 64
танай _____-ны № _____-г

ЦЭЦЭРЛЭГ СУМЫН ИТХ-ЫН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА Д.БОЛОРЦЭЦЭГ
ТАНАА

Аудитын санал дүгнэлт**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цэцэрлэг сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ. Цэцэрлэг сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой. Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Т.БАЙГАЛМАА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	3,244,900.00	3,244,900.00
35	БАРАА МАТЕРИАЛ	3,244,900.00	3,244,900.00
35400	Хангамжийн материал	3,244,900.00	3,244,900.00
35410	Бичиг хэргийн материал	80,000.00	80,000.00
35420	Аж ахуйн материал	3,164,900.00	3,164,900.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,353,382.90	6,665,366.14
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,353,382.90	6,665,366.14
39200	Биет хөрөнгө	3,353,382.90	6,327,032.80
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	5,066,395.00	8,466,395.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-3,190,296.44	-3,778,279.52
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	3,763,653.00	4,363,653.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-2,286,368.66	-2,724,735.68
39300	Биет бус хөрөнгө	0.00	338,333.34
39301	Програм хангамж	0.00	350,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	0.00	-11,666.66
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	6,598,282.90	9,910,266.14
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,598,282.90	9,910,266.14
51	Засгийн газрын хувь оролцоо	6,598,282.90	9,910,266.14
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,985,400.00	1,985,400.00
51200	Хуримтлагдсан үр дүн	4,277,017.45	7,589,000.69
51210	Өмнөх үеийн үр дүн	2,709,067.10	4,277,017.45
51220	Тайлант үеийн үр дүн	1,567,950.35	3,311,983.24
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	335,865.45	335,865.45
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	6,598,282.90	9,910,266.14

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	67,404,900.00	73,258,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	67,404,900.00	73,258,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	1,370,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	1,370,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	67,404,900.00	71,888,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	67,404,900.00	71,888,800.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	65,836,949.65	69,946,816.76
21	УРСГАЛ ЗАРДАЛ	65,836,949.65	69,946,816.76
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	50,861,625.86	69,073,316.57
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	37,873,794.77	49,195,416.81
210101	Үндсэн цалин	37,873,794.77	49,195,416.81

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,650,881.44	6,344,383.00
210201	Тэтгэврийн даатгал	3,199,079.17	4,414,859.70
210202	Тэтгэмжийн даатгал	364,508.82	491,959.96
210203	ҮОМШӨ-ний даатгал	312,877.99	393,567.93
210204	Ажилгүйдлийн даатгал	65,457.46	89,020.93
210205	Эрүүл мэндийн даатгал	708,958.00	954,974.48
2104	Хангамж, бараа материалын зардал	2,913,300.00	2,921,550.00
210401	Бичиг хэрэг	1,013,300.00	1,274,500.00
210402	Тээвэр, шатахуун	1,750,000.00	1,387,050.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	150,000.00	150,000.00
210404	Ном, хэвлэл	0.00	110,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	50,000.00	200,000.00
210604	Урсгал засвар	50,000.00	200,000.00
2107	Томилолт, зочны зардал	352,000.00	800,000.00
210702	Дотоод албан томилолт	352,000.00	800,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,096,300.00	682,050.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,096,300.00	682,050.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,925,349.65	8,929,916.76
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	3,309,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,000,000.00	4,582,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	925,349.65	1,038,016.76
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,975,323.79	873,500.19
2132	Бусад урсгал шилжүүлэг	511,000.00	575,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	511,000.00	575,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	14,464,323.79	298,500.19
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,464,323.79	298,500.19
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,567,950.35	3,311,983.24
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,567,950.35	3,311,983.24

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,985,400.00	335,865.45	2,709,067.10	5,030,332.55
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,985,400.00	335,865.45	2,709,067.10	5,030,332.55
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	1,567,950.35	1,567,950.35
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,985,400.00	335,865.45	4,277,017.45	6,598,282.90
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,985,400.00	335,865.45	4,277,017.45	6,598,282.90
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,985,400.00	335,865.45	4,277,017.45	6,598,282.90
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	3,311,983.24	3,311,983.24
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,985,400.00	335,865.45	7,589,000.69	9,910,266.14

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	67,404,900.00	73,258,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	67,404,900.00	73,258,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	1,370,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	1,370,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	67,404,900.00	71,888,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	67,404,900.00	71,888,800.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	67,004,900.00	68,908,800.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	67,004,900.00	68,908,800.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	51,240,576.21	68,110,299.81
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	37,873,794.77	49,195,416.81
210101	Үндсэн цалин	37,873,794.77	49,195,416.81
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,650,881.44	6,344,383.00
210201	Тэтгэврийн даатгал	3,199,079.17	4,414,859.70
210202	Тэтгэмжийн даатгал	364,508.82	491,959.96
210203	ҮОМШӨ-ний даатгал	312,877.99	393,567.93
210204	Ажилгүйдлийн даатгал	65,457.46	89,020.93
210205	Эрүүл мэндийн даатгал	708,958.00	954,974.48
2104	Хангамж, бараа материалын зардал	3,656,600.00	3,050,500.00
210401	Бичиг хэрэг	1,356,600.00	1,150,500.00
210402	Тээвэр, шатахуун	1,750,000.00	1,550,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	150,000.00	150,000.00
210404	Ном, хэвлэл	400,000.00	200,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	300,000.00	200,000.00
210604	Урсгал засвар	300,000.00	200,000.00
2107	Томилолт, зочны зардал	352,000.00	800,000.00
210702	Дотоод албан томилолт	352,000.00	800,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,407,300.00	500,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,407,300.00	500,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,000,000.00	8,020,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	3,450,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,000,000.00	4,570,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,764,323.79	798,500.19
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,300,000.00	500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,300,000.00	500,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	14,464,323.79	298,500.19
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,464,323.79	298,500.19
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	400,000.00	4,350,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	400,000.00	4,350,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	400,000.00	4,350,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	400,000.00	4,350,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	400,000.00	4,350,000.00

VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-400,000.00	-4,350,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.00	0.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	71,888,800.00	71,590,299.81	298,500.19	99.58
21	УРСГАЛ ЗАРДАЛ	71,888,800.00	71,590,299.81	298,500.19	99.58
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	71,388,800.00	71,090,299.81	298,500.19	99.58
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	49,196,700.00	49,195,416.81	1,283.19	100.00
210101	Үндсэн цалин	49,196,700.00	49,195,416.81	1,283.19	100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,641,600.00	6,344,383.00	297,217.00	95.52
210201	Тэтгэврийн даатгал	4,673,700.00	4,414,859.70	258,840.30	94.46
210202	Тэтгэмжийн даатгал	492,000.00	491,959.96	40.04	99.99
210203	ҮОМШӨ-ний даатгал	393,600.00	393,567.93	32.07	99.99
210204	Ажилгүйдлийн даатгал	98,400.00	89,020.93	9,379.07	90.47
210205	Эрүүл мэндийн даатгал	983,900.00	954,974.48	28,925.52	97.06
2104	Хангамж, бараа материалын зардал	3,050,500.00	3,050,500.00	0.00	100.00
210401	Бичиг хэрэг	1,150,500.00	1,150,500.00	0.00	100.00
210402	Тээвэр, шатахуун	1,550,000.00	1,550,000.00	0.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	150,000.00	150,000.00	0.00	100.00
210404	Ном, хэвлэл	200,000.00	200,000.00	0.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,200,000.00	4,200,000.00	0.00	100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,000,000.00	4,000,000.00	0.00	100.00
210604	Урсгал засвар	200,000.00	200,000.00	0.00	100.00
2107	Томилолт, зочны зардал	800,000.00	800,000.00	0.00	100.00
210702	Дотоод албан томилолт	800,000.00	800,000.00	0.00	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	500,000.00	500,000.00	0.00	100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	500,000.00	500,000.00	0.00	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,000,000.00	7,000,000.00	0.00	100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,500,000.00	2,500,000.00	0.00	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,500,000.00	4,500,000.00	0.00	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	500,000.00	500,000.00	0.00	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	500,000.00	500,000.00	0.00	100.00

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	500,000.00	0.00	100.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	71,888,800.00	71,590,299.81	298,500.19	99.58
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	62,538,800.00	71,590,299.81	9,051,499.81	114.47
320001	Орон нутгийн төсвөөс	62,538,800.00	71,590,299.81	9,051,499.81	114.47
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	9,350,000.00	0.00	9,350,000.00	0.00
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	9,350,000.00	0.00	9,350,000.00	0.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	2.00	2.00	0.00	100.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	1.00	1.00	0.00	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,370,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,370,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,370,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,370,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	950,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	420,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,370,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,370,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,370,000.00
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Цэцэрлэг сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор П.Энхжаргал гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Цэцэрлэг сумын ИТХ нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 02/01 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Цэцэрлэг сумын ИТХ нь Нутгийн өөрөө удирдах байгууллагын шийдвэр, Улсын Их Хурлаас гаргасан хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, түүнтэй нийцүүлэн гаргасан нутгийн захиргааны шийдвэрүүдэд хяналт тавьж биелэлтийг хангуулахын тулд үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын хяналтын багийн чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цэцэрлэг сумын ИТХ нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвөөс сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 71.9 сая төгрөгөөс 1%-иар буюу 0.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу буюу 0.5 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн эхний үлдэгдлээс 0.2 сая төгрөгөөр буурсан байна. Оны эхний үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан данс нь бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	Хувь
Бараа материал	3.2	3.2	0	0.0
Үндсэн хөрөнгө	3.4	6.7	3.3	97.1
Нийт хөрөнгө	6.6	9.9	3.3	50.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	6.6	9.9	3.3	50.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	6.6	9.9	3.3	50.0

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- *Бараа материал эхний үлдэгдэл өөрчлөгдөөгүй байна.*

Бараа материалын данс нь 3.2 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 10.2 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд 10.2 сая төгрөгийн бараа материалыг зарцуулан оны эцэст 3.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- *Үндсэн хөрөнгө эхний үлдэгдлээс 0.2 хувиар буурсан байна.*

Үндсэн хөрөнгө данс нь 3.4 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 4.3 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант хугацаанд байгуулсан 1.0 сая төгрөгийн элэгдлийн зардлаар буурч 6.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- *Цэвэр хөрөнгө өмчийн дүн өссөн нь тайлант хугацааны үр дүнтэй холбоотой бөгөөд тайлант хугацаанд 3.3 сая төгрөгийн үр дүнг хүлээн зөвшөөрсөн байна.*

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/сая.төгрөг/		
	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	67.4	71.9	4.5
Нэмэлт санхүүжилтийн орлого		1.4	1.4
Үйл ажиллагааны орлого	67.4	73.3	5.9
Бараа үйлчилгээний зардал	50.9	69.1	18.2
Урсгал шилжүүлэг	15	0.9	-14.1
Үйл ажиллагааны зардал	65.9	70	4.1
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1.5	3.3	1.8

Цэцэрлэг сумын ИТХ-ын санхүүгийн үр дүнгийн тайлангийн урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн орлого өмнөх оноос 5.9 сая төгрөг буюу 8 хувиар өссөн нь тэтгэвэрт

гарахад олгодог санхүүжилттэй холбоотой бөгөөд төлөвлөсөн санхүүжилтийг зарцуулж ажилласан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 62.9 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг нийт 9.0 сая төгрөгөөр бууруулж нийт зардлыг 71.9 сая төгрөгөөр хянаж баталжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 71.9 сая төгрөгийн төсөв батлагджээ. Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 71.9 сая төгрөгийн санхүүжилт авч 71.6 сая төгрөгийг урсгал үйл ажиллагаандаа зарцуулж 0.3 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Төвлөрүүлэх шилжүүлэг нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 0.3 сая төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 1.4 сая төгрөг Аймгийн ИТХ-ын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардалд зориулан зарцуулахаар ирсэн байна. Анхан шатны баримтаас тулган шалгахад 0.4 сая төгрөг цахим хурлын нэгжний зардалд, 1.0 сая төгрөгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх урамшуулалт эргүүлийн зардалд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд хурлын төлөөлөгч нар тойргийн иргэдэд ковидоос урьдчилан сэргийлэх заавар зөвлөмж хүргүүлэх ажлаар 0.7 сая төгрөгийн шатахуун зарцуулж ажилласан байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллага нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн 6 үндсэн зорилтын хүрээнд 40 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээг 91.2 хувь хэрэгжүүлсэн байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд зориулан нийт 71.9 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 71.6 сая төгрөгийг зарцуулж, 99.6 хувийн биелэлттэй.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэллээ. Үүнд:

1. Төсвийн хэмнэлтийн талаар авсан арга хэмжээ, түүний үр дүн судалгааг авч үзэхэд Цэцэрлэг сумын ИТХ нь 3.4 сая төгрөгөөр тоног төхөөрөмж, 0.6 сая төгрөгөөр тавилга, эд хогшил бэлтгэсэн ЗГ-ын 43-р тогтоолын 1.4 дэхь заалтыг зөрчсөн байна.

Харин бусад судалгаанд хамаарах мэдээлэлгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан /Local.audit.mn сайтад шивсэн/, Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай ЗГ-ын 43-р тогтоолын хэрэгжилтийг судалгаагаар шалгаж баримтжууллаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зорицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Цэцэрлэг сумын ИТХ нь тайлант хугацаанд шилэн дансанд оруулбал зохих 143 мэдээллээс 141 мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна. Харин 2 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “4.1.3.тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг хүргүүлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайланд онд Монгол улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллахыг бүх шатны төсөв захирагчид даалгасан. Тус байгууллага нь батлагдсан төсвийн 1.8 хувийг хэмнэж 0.3 сая төгрөгийг төвлөрүүлсэн ба 8.2 хувийн буюу 1.3 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгоогүй байна.

Энэ нь Төсвийг хэмнэлтийн Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.1-д заасан “үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, арга хэмжээг тэвчиж, зардал гаргахгүй байх, батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гарахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэсэн заалттай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын 43-р тогтоолыг мөрдөж ажиллах албан шаардлагыг хүргүүлэх

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, бусад хууль тогтоомжийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилт холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Цэцэрлэг сумын ИТХ-д завсрын аудит хийгээгүй байна. Өмнөх жилийн санхүүгийн тайлангийн аудитаар дотоод хяналттай холбоотой зөвлөмж хүргүүлснийг хэрэгжүүлж биелэлтийг 2021 оны 5 дугаар сарын 31-ний 02/15 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.12 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар тээвэр шатахууны зардлын зарцуулалтыг тулган шалгана.

4. Аудитын илрүүлэлт

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчил нь материаллаг бус тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

Төсвийн хэмнэлтийн талаар авсан арга хэмжээ, түүний үр дүн судалгааг авч үзэхэд Цэцэрлэг сумын ИТХ нь 0.6 сая төгрөгөөр тавилга, эд хогшил бэлтгэсэн ЗГ-ын 43-р тогтоолын 1.4 дэхь заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

-----oOo-----

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
/сая төгрөгөөр/											
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Цэцэрлэг сумын ИТХ										
Санхүүгийн тайлангийн аудитын шалгасан нийцлийн аудитын асуудал											
2	Цэцэрлэг сумын ИТХ	3	1.9					2	1.9	1	
НИЙТ ДҮН		3	1.9					2	1.9	1	